



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 10 дугаар
сарын 06 өдөр

Дугаар 6-239

Улаанбаатар
хот

Комиссын бүрэлдэхүүн дүрмийг батлах тухай

1. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тус комиссын дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталжугай.

2. Хууль зүйн сайд Гэгээрлийн сайдын 1997 оны 245/257 тоот хамтарсан тушаалаар батлагдсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгох журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авчгүүнийг биеэлэл хяналт тавьж дүнг улирлыг тутам холбогдох байгууллагад мэдүүлж ажиллахыг комисс /Э/ омбожав/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д. ашчаар /ЖНАРАНЦАЦРАЛ/



Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт
эрхлэх зовшоорол олгох хяналт тавих хотын
комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга

- Улаанбаатар хотын ерөнхий менежер

Орлогч дарга

- Замын цагдаагийн газрын дарга

Нарийн бичгийн дарга

- Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн сургалт,

мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Гийгууд:

- Замын цагдаагийн газрын мэргэжлийн
комиссын дарга

- Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

- Гэгээрлийн яамны мэргэжилтэн

- Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн
зах зээл зохицуулалтын асуудал хариуц-
сан мэргэжилтэн

- Хотын Тээвэр зохицуулалтын газрын
хэлтсийн дарга

- Боловсролын улсын хяналтын албаны
үжэн байцаагч

- Хотын Хэрэглэгчдийн зох ашгийг хам-
гаалах нийгэмлэгийн дарга

- Хотын ЭАХСХ Албаны дарга

- хотын Татварын газрын дарга

- Нийслэлийн Газрын харилцаа, Үл хөдлөх
хөрөнгийн бүртгэлийн албаны дарга



Тээврийн хэрэгсэлийн жолооч бэлтгэх
сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт
тавих хотын комиссийн дүрэм

Нэг. Зорилго

Энэхүү комиссын зорилго нь тээврийн хэрэгсэлийн жолооч бэлтгэх, сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, сургалтын төсөр, мөргөжлийн байгууллагуулын дүтгэмлүүд хэр зэрэг үндэслэлтэй өгөлдсөн гэрээт хяналт тавьж зохицуулах, судалгаа дүн шинжилгээ авах, жолоочын хэмжээнуудын сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх, зэм тээврийн ослыг баригдахтай холбогдсон зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Нийтлэх зүйл

1. Жолооч бэлтгэх сургалтын зорилго, агуулга, хөтөлбөр нь иргэн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.
2. Сургалт явуулах материалыг бэлд, мөргөжлийн байцаар бүрэн хангагдсан, сургалт явуулах зөвшөөрөл авсан байгууллага аж ахуйн нэгж, хууль тогтоомжид шингүүрж жолооч бэлтгэх сургалт явуулна.
3. Жолооч бэлтгэх сургалт явуулах үйл ажиллагаа нь уг сургалт явуулах байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэсэн өдрөөс хувийн төгөлдөр болно.
4. Эрүүл мэндийн шаардлага хангасан, сургалтыг төгсөх үедээ 18 нас хүрсэн шинэтэй хотод баянгын бүртгэлтэн буюу түр шинэжүүлэгтэн иргэн жолооч бэлтгэх сургалтад хамрагдах эрхтэй. Жолооч бэлтгэх сургалтад хамрагдсан сонсогч сонгуугаар болон жолоодох эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодох нь тогтоогдсон бол уг сургалтаас хасна.
5. Сургалт явуулах эгтгэл нь сонсогч, байц нэр болон холбогдох байгууллагатай гэрээ байгуулах болонд уг гэрээнд хоёр талын хүлээх үүрэг хариуцлагыг хууштай.
6. Жолооч бэлтгэх сургалтыг 9 дүгээр сарын 1 нээх дараа жилийн 7 дугаар сарын 1 ний хооронд явуулна.

*Гурав. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх
зөвшөөрөл олгоход тавих шаардлага*

Доорхи шаардлагыг хангасан тохиолдолд жолооч бэлтгэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгоно. Үүнд:

Сургалт явуулах этгээд нь зохих норм, дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан, зохих үзүүлэлтэй, шаардлага хангасан хичээлийн талхимтай байна. Хичээлийн талхим нь хүрэлцэхүйц тооны сандал ширээ, самбартай байна.

Зохих шаардлага хангасан жолоодлогын дэдлагын талбайтай байна. /Орлогын хягааралт бүхий хонгил, наймын тоо, ухрах талбайг үүнээс эсхэлд, туг сүлжих, хажуугийн зогсоол /

Зохих шаардлага хангасан багшлах бүрэлдэхүүнтэй байна.

*Дөрөв. Сургалт эрхлэх зөвшөөрөл авах тухай
өргөдлийг хүлээн авах, хлиах, зөвшөөрөл олгох*

1. Жолооч бэлтгэх сургалт зохион байгуулах сонирхолтой, энэхүү дүрмийн хоёрдугаар хэсэгт тавьсан шаардлагыг хангасан байгууллага, аж ахуйн нэгж зөвшөөрөл авахын тулд батлагдсан зааварын дагуу үйлдсэн өргөдлөө Нийслэлийн захирагчийн ажлын албанд ирүүлнэ. Өргөдөл дор дурдсан материалуудыг хавсаргана.

Үүнд:

- Сургалт явуулах этгээдийн танилцуулга

- Орлогын татварын тооцоо хийсэн тухай татварын байгууллагын тодорхойлолт

- Тээврийн хэрэгсэл, жолоодлогын талбай, замын хөдөлгөөний дүрмийн болон техникийн хичээлийн үзүүлэлт, багш нар зохих шаардлага хангаж буй тухай Замын цагдаагийн газрын дүгнэлт

- Хичээлийн талхим сургалт явуулах эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт

- Жолоодлогын талбайг ашиглалтын тухай Нийслэлийн газрын харилцаа үл хөдлөх Хөрөнгийн бүртгэлийн албаны тодорхойлолт

2. Комисс нь өргөдөл авлаас хойш 15 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Баримт бичиг бүрдэл болоогүй тохиолдолд түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор буцаана.

3. Комисс нь өргөдлийг хүлээж авалд сургалт явуулах нөхцөл бүрдсэн гэж үзвэл зөвшөөрөл олгох дүгнэлт гаргана.

4. Зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар олгоно.

5. Мэргэжлийн комисс ба холбогдох хяналтын байгууллага нь жолооны курсыг эхлэх төгсөх бүрт тусгай үзүүлэлтийн дагуу шалгалт аттестатчиллыг явуулж шаардлага хангаагүй тохиолд комисст асуудлыг тавьж эрхийг хүчингүй болгох, сунгах түр буюу бүр хугацаагаар хаах санал оруулж шийдвэрлүүлнэ.

5. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эгтээд жолооч бэлтгэх сургалт явуулах бүрдээ сургалтын нөхцлөө шалгуулж зөвшөөртөө баталгаажуулна.

6. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх зөвшөөрөл авахаар хүсэлт тавьсан байгууллага зөвшөөрөгдсөн тохиолдолд Монгол улсын тэмдэгийн хураамжийн дагуу 12500 төгрөг, сургалтыг баталгаажуулахад 8000 төгрөг тушаана.

7. Сургалт явуулах зөвшөөрөл авсны дараа анх өргөдөлд өгсөн материалд өөрчлөлт оруулах шаардлага гарсан бол энэ тухай комисст 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэж зөвшөөрөлийн баримт бичигт өөрчлөлт хийлгэнэ.

8. Комисс нь хотын захирагчийн ажлын албаны бланк, тэмдэг хэрэглэнэ.

Тав. Журмын хэрэгжилтэнд хяналт тавих

1. Хотын ЗОЖ нь тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, сургалт явуулах зөвшөөрөл олгохтон холбогдолтой үзлэг шалгалтыг холбогдох хяналтын байгууллагуудтай хамтран төлөвлөж явуулахаас гадна бие даан гэгцэт болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж, үр дүнг хэлэлцэн арга хэмжээ авч ажиллана.

2. Тухайн дамжааны талаар сонсогчдоош томдол гаргасан, сургалтын явцад дамжуурсан буюу чанаргүй сургалт явуулсан, мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт шаардлагын хэмжээнд хүрээгүй, томдол мэдээллийг газар дээр нь шалгаад бодитой гэж үзвэл мөн хяналт тавих явцад энэ журам ноптой зөрчилдөж байвал тухайн сургалтын зөвшөөрлийг хүчингүй болгох, зөрчил дутагдлыг арилгуулах, буруутай эгтээдэд хариуцлага тооцох зэрэг асуудлыг ЗОЖ-ын хуралд оруулж санал, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр зохих шийдвэрийг гаргуулна.

3. Зөвшөөрлийг түр хурааж хугацаатай үүрэг өгснөөс хойш нэг сарын дотор уг зөрчлийг арилгуулаагүй бол хүчингүй болгох асуудлыг ЗОЖ-ын хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

Уг зөвшөөрөл нь хүчингүй болсноос хойш нэг жил буюу шаардлагатай бол бүр мөхөн хугацаанд уг аж ахуйн нэгжил дахин зөвшөөрөл олгохгүй.

4. Комиссын хурлыг сард нэг удаа хийх ба шаардлагатай нөхцөлд цаг үеийн асуудлыг хэлэлцэхээр хуралдуулж болно.